



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/17/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: Khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Энхжин
Утас: 261740 Цахим хаяг: Enhkhjinb@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Бүгүнүтэй
Утас: 261740 Цахим хаяг: Bugunuteie@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	10
3.5.2 Авлага	11
3.5.3 Урьдчилгаа	11
3.5.4 Бараа материал	12
3.5.5 Үндсэн хөрөнгө	12
3.5.6 Өр төлбөр	13
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Харьяа байгууллагууд.....	17
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УБХ	Улсын бүртгэлийн хэсэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА
Д.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

2022.03.25 № 01/711
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

001051140

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,972,883.2	13,132,532.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	107,009.0	893,013.4
33	АВЛАГА	31,162.3	39,715.6
35	БАРАА МАТЕРИАЛ	9,174,761.6	12,099,803.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	7,495,181.0	100,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,023,692.6	40,561,833.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,023,692.6	40,561,833.6
39200	Биет хөрөнгө	13,762,219.6	38,929,543.0
39300	Биет бус хөрөнгө	2,261,473.0	1,632,290.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	33,996,575.7	53,694,366.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	107,203.4	887,892.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	107,203.4	887,892.7
41300	Өглөг	10,004.9	1,698.7
41400	Урьдчилж орсон орлого	97,198.4	886,194.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	33,889,372.4	52,806,473.5
51	Засгийн газрын хувь оролцоо	33,889,372.4	52,806,473.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,211,503.2	12,211,503.2
51200	Хуримтлагдсан үр дүн	21,167,084.8	40,084,186.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	510,784.3	510,784.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	33,996,575.7	53,694,366.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	54,349,240.4	54,490,392.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,463,939.5	10,273,450.0
120	Нийтлэг татварын бус орлого	2,463,939.5	10,273,450.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,885,300.9	44,216,942.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	38,808,935.3	35,617,986.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,808,935.3	35,617,986.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,752,756.5	34,783,240.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,059,778.2	16,848,089.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,249,104.4	2,322,879.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,616,397.4	1,062,937.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,177,840.4	2,033,906.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	284,624.1	222,168.9
2107	Томилолт, зочны зардал	34,503.2	19,003.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,545,165.5	4,142,732.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,785,343.2	8,131,523.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,056,178.8	834,746.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	15,540,305.1	18,872,405.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,674,529.4	40,296.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	13,865,775.7	18,832,108.8

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,058,066.8	-	20,058,066.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	74,329.2	-	74,329.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,132,396.0	-	20,132,396.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(108,799.4)	-	(108,799.4)
9	Тайлант үеийн үр дүн	13,865,775.7	-	13,865,775.7
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,889,372.4	-	33,889,372.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	84,992.4	-	84,992.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,974,364.7	-	33,974,364.7
19	Тайлант үеийн үр дүн	18,832,108.8	-	18,832,108.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	52,806,473.5	-	52,806,473.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		66,982,053.6	64,532,394.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		15,021,787.5	19,142,988.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		15,021,787.5	19,142,988.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		15,021,787.5	19,142,988.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		74,965.3	1,171,464.7
120	Нийтлэг татварын бус орлого		74,965.3	1,171,464.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		51,885,300.9	44,217,942.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		53,603,167.6	50,538,438.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		53,603,167.6	50,538,438.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		37,543,158.7	30,598,130.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		15,771,102.3	16,461,284.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,307,835.7	2,588,361.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,616,397.4	1,063,415.3
2104	Хангамж, бараа материалын зардал		680,590.9	794,666.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,105,242.8	166,692.2
2107	Томилолт, зочны зардал		34,503.2	19,032.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,434,784.1	5,457,021.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		10,592,702.3	4,047,656.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		16,060,008.9	19,940,308.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		13,378,886.0	13,993,956.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		13,320,690.5	13,207,952.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		13,320,690.5	13,207,952.3
2200	Дотоод эх үүсвэрээр		13,320,690.5	13,207,952.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(13,320,690.5)	(13,207,952.3)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		58,195.6	786,004.4

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		48,813.5	107,009.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		107,009.0	893,013.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,056,773,800.00	41,954,970,090.25	101,803,709.75	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,615,773,800.00	31,563,617,158.50	52,156,641.50	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,865,050,500.00	30,813,537,090.50	51,513,409.50	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,196,809,800.00	16,188,987,975.60	7,821,824.40	100.0
210101	Үндсэн цалин	11,895,060,200.00	11,889,666,924.52	5,393,275.48	100.0
210102	Нэмэгдэл	3,005,115,500.00	3,004,908,062.98	207,437.02	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,296,634,100.00	1,294,412,988.10	2,221,111.90	99.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,612,969,600.00	2,585,341,762.66	27,627,837.34	98.9
210201	Тэтгэврийн даатгал	1,973,342,400.00	1,946,240,303.97	27,102,096.03	98.6
210202	Тэтгэмжийн даатгал	160,609,300.00	159,981,560.55	627,739.45	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	127,969,800.00	128,063,189.46	(93,389.46)	100.1
210204	Ажилгүйдлийн даатгал	32,045,400.00	32,106,075.85	(60,675.85)	100.2
210205	Эрүүл мэндийн даатгал	319,002,700.00	318,950,632.83	52,067.17	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,066,928,800.00	1,058,815,275.53	8,113,524.47	99.2
210301	Гэрэл, цахилгаан	170,115,000.00	167,705,780.63	2,409,219.37	98.6
210302	Түлш, халаалт	318,161,400.00	315,439,586.62	2,721,813.38	99.1
210303	Цэвэр, бохир ус	31,434,300.00	28,495,826.28	2,938,473.72	90.7
210304	Байрны түрээс	547,218,100.00	547,174,082.00	44,018.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	668,037,500.00	664,944,042.02	3,093,457.98	99.5
210401	Бичиг хэрэг	328,828,400.00	328,804,297.19	24,102.81	100.0
210402	Тээвэр, шатахуун	94,310,800.00	94,301,477.00	9,323.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	106,968,900.00	105,271,934.75	1,696,965.25	98.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,481,300.00	6,190,325.00	1,290,975.00	82.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	130,448,100.00	130,376,008.08	72,091.92	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	331,014,300.00	330,140,437.00	873,863.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	260,705,000.00	260,382,267.00	322,733.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	32,927,900.00	32,519,210.00	408,690.00	98.8
210604	Урсгал засвар	37,381,400.00	37,238,960.00	142,440.00	99.6
2107	Томилолт, зочны зардал	18,153,100.00	17,707,550.00	445,550.00	97.5
210701	Гадаад албан томилолт	1,651,100.00	1,650,000.00	1,100.00	99.9
210702	Дотоод албан томилолт	16,502,000.00	16,057,550.00	444,450.00	97.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,362,129,500.00	5,359,133,749.15	2,995,750.85	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,617,481,400.00	4,617,161,059.15	320,340.85	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,555,000.00	7,139,000.00	1,416,000.00	83.4
210803	Даатгалын үйлчилгээ	9,995,200.00	9,762,714.00	232,486.00	97.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,637,800.00	3,428,678.00	209,122.00	94.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	660,000.00	594,000.00	66,000.00	90.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	136,400,000.00	136,400,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	3,482,000.00	3,378,630.00	103,370.00	97.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	177,900.00	12,000.00	165,900.00	6.7

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	581,740,200.00	581,257,668.00	482,532.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,609,007,900.00	4,608,466,298.54	541,601.46	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,565,000,000.00	4,564,801,873.54	198,126.46	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,007,900.00	43,664,425.00	343,475.00	99.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	750,723,300.00	750,080,068.00	643,232.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	750,723,300.00	750,080,068.00	643,232.00	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	358,294,800.00	357,986,640.00	308,160.00	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	392,428,500.00	392,093,428.00	335,072.00	99.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,441,000,000.00	10,391,352,931.75	49,647,068.25	99.5
220001	Барилга байгууламж	7,600,000,000.00	7,550,455,123.00	49,544,877.00	99.3
222001	Тоног төхөөрөмж	2,841,000,000.00	2,840,897,808.75	102,191.25	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,056,773,800.00	41,954,970,090.25	101,803,709.75	99.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,056,773,800.00	41,954,970,090.25	101,803,709.75	99.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	42,056,773,800.00	41,954,970,090.25	101,803,709.75	99.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,559	2,559	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	-	100.0
610001	Төсвийн байгууллага	23	23	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,268	1,268	-	100.0
620001	Удирдах ажилтан	40	40	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1,116	1,116	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	64	64	-	100.0
620004	Гэрээт ажилтан	48	48	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,268	1,268	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,095	1,095	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	173	173	-	100.0

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,942,626,664.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,942,626,664.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,913,545,807.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		272,296,934.01
210101	Үндсэн цалин		2,520,000.00
210102	Нэмэгдэл		248,442,452.00
210105	Гэрээт ажлын хөлс		21,334,482.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,019,374.76
210201	Тэтгэврийн даатгал		3,019,374.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,600,000.00
210304	Байрны түрээс		4,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		130,753,930.00
210401	Бичиг хэрэг		96,841,390.00
210402	Тээвэр, шатахуун		25,919,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,541,560.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,271,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		63,363,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		24,460,300.00
210602	Тавилга		37,434,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		735,000.00

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар		734,000.00
2107	Томилолт, зочны зардал		1,325,000.00
210702	Дотоод албан томилолт		1,325,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		278,253,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		167,609,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,331,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		109,312,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,159,934,169.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,123,078,169.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		36,856,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		29,080,856.10
2132	Бусад урсгал шилжүүлэг		15,848,420.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		15,848,420.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		13,232,436.10
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		13,232,436.10
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,942,626,664.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,942,626,664.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		632,628,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,229,811,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		80,186,414.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад төсвийн хэмнэлтийн талаар гаргасан ЗГ-ын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-аас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд ахлах аудитор Б.Энхжин, аудитор Э.Бүгүнүтэй нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 1/1659 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлжээ. Тус байгууллагын чиг үүргийг Монгол Улсын төр засгаас улсын бүртгэлийн чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлж, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд, олон нийтэд чанартай, шуурхай хүргэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь 2021 онд 7 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэсэн байна. Улсын бүртгэлийн 21 аймаг, 6 дүүргийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээгээр эхний хагас жилийн байдлаар УБЕГ, БТДШГ үнэлгээ хийж үнэлгээний танилцуулгыг хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 54,490.4 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 1,089.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,697.7 сая төгрөгөөр буюу 63.3 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилж орсон орлого данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 893.0 сая төгрөг болж, өмнөх оноос 786.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	95,201.2	840,567.3	745,366.1
Арилжааны банк дахь харилцах	1,358.2	6,756.6	5,398.4
Замд яваа мөнгөн хөрөнгө	10,449.7	45,689.6	35,239.9
Дүн	107,009.0	893,013.4	786,004.4

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 94.9 хувь буюу 847.3 сая төгрөгийг банканд байгаа бэлэн мөнгө эзэлж байна. Үүнээс төрийн сангийн харилцах дансанд 840.5 сая төгрөг, арилжааны банкин дахь харилцах дансанд 6.8 сая төгрөг байршиж байна.

Төрийн сангийн харилцах данс 840.6 сая төгрөг болж өмнөх оноос 745.4 сая төгрөгөөр өссөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гэрээний дагуу суутгасан барьцаа хөрөнгийг төрийн сангийн харилцах дансанд байршуулснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 30.1 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн /Булган аймаг дахь УБХ 0.1 сая төгрөг, Сэлэнгэ аймаг дахь УБХ 30.0 сая төгрөг/;
- И-баримтаар баталгаажуулаагүй бараа, ажил үйлчилгээний 5.3 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн /Завхан аймаг дахь УБХ 2.1 сая, Төв аймаг дахь УБХ 3.2 сая төгрөг/;
- Ажилчдын цалин хөлс, ээлжийн амралтын мөнгийг 0.9 сая төгрөгөөр давхардуулан олгосон /Говь-Алтай аймаг дахь УБХ 0.2 сая, Говьсүмбэр аймаг дахь УБХ 0.4 сая, Сэлэнгэ аймаг дахь УБХ 0.3 сая төгрөг/;
- Дархан аймаг дахь УБХ үйлчилгээний ажиллагсдад ур чадварын нэмэгдлийг олгохдоо ажлын үр дүнг тодорхой шалгуур үзүүлэлтээр дүгнээгүй 5.4 сая төгрөгийг олгосон;
- Дорнод аймаг дахь УБХ ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүйгээр 46.8 сая төгрөгийг зардалд шууд бүртгэсэн;
- Зардлыг зориулалт бусаар зарцуулсан, төсвийн хөрөнгийг хяналтгүй зарцуулсан, шатахууны зардлыг илүү тооцож олгосон, ээлжийн амралтаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй зэрэг 5.2 сая төгрөгийн алдаа зөрчил байна. /Дорноговь аймаг дахь УБХ 1.5 сая, Ховд аймаг дахь УБХ 3.2 сая, Төв аймаг дахь УБХ 0.2 сая, Баянхонгор аймаг дахь УБХ 0.3 сая төгрөг/;
- Монгол Улсын Засгийн газрын Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаагүй 2.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн /Говь-Алтай аймаг дахь УБХ 1.3 сая, Хэнтий аймаг дахь УБХ 1.2 сая төгрөг, Архангай аймаг дахь УБХ, Сэлэнгэ аймаг дахь УБХ/;
- УБЕГ аж ахуй нэгжтэй байгуулсан 49.8 сая төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, акт үйлдээгүй, харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 39.7 сая төгрөг болж, өмнөх оноос 8.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт(-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	105.8	1,437.7	1,331.9
Байгууллагаас авах авлага	16,888.1	38,277.9	21,389.9
Хувь хүмүүсээс авах авлага	14,168.4	-	(14,168.4)
Дүн	31,162.3	39,715.6	8,553.3

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага данс өмнөх оноос 8.5 сая төгрөгөөр өссөн нь хувь хүнээс авах авлага барагдсан дүнгээр буурч, байгууллагаас авах авлага 21.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Нийслэл дэх УБХ татварын цахим системд татварын өр, авлагын үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс эцсийн үлдэгдэлгүй болж, өмнөх оноос 1,164.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	1,164,769.2	-	(1,164,769.2)
Дүн	1,164,769.2	-	(1,164,769.2)

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 1,164.7 сая төгрөгийн ажил, гүйлгээг тайлант онд хүлээн авч хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 12,099.8 сая төгрөг болж, өмнөх оноос 2,925.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	5,897,827.9	8,304,422.1	2,406,594.2
Бэлэн бүтээгдэхүүн	2,340,883.7	2,421,615.8	80,732.0
Бичиг хэргийн материал	291,234.1	301,397.4	10,163.3
Аж ахуйн материал	266,481.5	490,520.8	224,039.3
Сэлбэг хэрэгсэл	205,793.7	189,186.8	(16,606.9)
Түлш, шатах тослох материал	5,277.8	10,424.0	5,146.2
Барилгын засварын материал	-	194.0	194.0
Бусад хангамжийн материал	137,212.7	351,307.2	214,094.5
Биологийн хөрөнгө	9,010.1	55.5	(8,954.6)
Мал амьтад	21,040.0	30,680.0	9,640.0
Дүн	9,174,761.6	12,099,803.6	2,925,042.0

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны өсөлтөд тусгай зориулалтын материал буюу гадаад паспорт болон иргэний цахим үнэмлэхийн бэлдэц, төрсний гэрчилгээний болон нас барсны гэрчилгээний хавтас бэлдсэн 2,406.5 сая, аж ахуйн материал 224.0 сая, бусад хангамжийн материал 214.1 сая төгрөгөөр өссөн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материал худалдан авалтаар 7,765.7 сая төгрөг, байгууллага хооронд болон үндсэн хөрөнгө данснаас бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн 4,095.8 сая төгрөг, дуусаагүй үйлдвэрлэл, малын нас дэвшилт болон бусад нэмэгдлээр 29.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 6,565.0 сая төгрөг, шилжүүлсэн болон хоорондын тооцоогоор 2,143.8 сая төгрөг, бусад байдлаар хорогдсон болон хасагдсан 257.6 сая төгрөгийн бараа материалын дүнгээр буурчээ.

Аудитын илрүүлэлт:

- Сэлэнгэ аймаг дахь УБХ бичиг хэргийн материалын жилийн эцсийн үлдэгдлийг үнэн зөв тоолж, баталгаажуулаагүйгээс 0.3 сая төгрөгийн принтерийн хор дутагдсан;
- Говь-Алтай аймаг дахь УБХ сумдын улсын бүртгэгч нарт олгосон үнэт цаас, сэлбэг хэрэгслийн тооллогоор 2.0 сая төгрөгийн бараа материалыг тоолж баталгаажуулаагүй;
- Жилийн эцсийн бараа материалын тооллогоор 5.6 сая төгрөгийн материалыг тоолж баталгаажуулаагүй /Говь-Алтай аймаг дахь УБХ 2.0 сая, Төв аймаг дахь УБХ 3.6 сая төгрөг/;
- Сэлэнгэ аймаг дахь УБХ нэмэлт санхүүжилтээр худалдан авч, зарцуулсан 6.7 сая төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэсэн;
- Орхон аймаг дахь УБХ бараа материалын бүртгэлд 1.2 сая төгрөгийн шатахууныг худалдан авсан өртгөөр бүртгэлд тусгаагүй байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 40,561.8 сая төгрөг болж, өмнөх оноос 24,538.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	13,762,219.6	38,929,542.9	25,167,323.3
Биет бус хөрөнгө	2,261,473.0	1,632,290.6	-629,182.4
Дүн	16,023,692.6	40,561,833.5	24,538,140.9

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 24,538.1 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 8,993.2 сая төгрөгийн барилгыг хүлээн авч орлогоор бүртгэсэн,

тайлант оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7,550.4 сая төгрөгийн барилга байгууламж, 2,840.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн нь голлон нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн данс худалдан авалтаар 11,192.1 сая төгрөг, байгууллага хооронд болон бараа материалын данснаас шилжүүлэн бүртгэсэн 8,843.3 сая төгрөг, бусад 9,893.8 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 42.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталсан 2,166.0 сая төгрөг, шилжүүлсэн болон хоорондын тооцоогоор 369.3 сая төгрөг, бусад байдлаар 48.9 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний хорогдол 103.7 сая төгрөгийн дүнгээр буурчээ.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн шинжтэй 38.6 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн. /Говь-Алтай аймаг дахь УБХ 6.5 сая; Орхон аймаг дахь УБХ 13.5 сая; Төв аймаг дахь УБХ 1.5 сая; Нийслэлийн УБГ 17.1 сая төгрөг/
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 44.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон шинэчлэн тогтоох үнийн саналыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлээгүй. /Архангай аймаг дахь УБХ, Нийслэлийн УБГ 44.3 сая төгрөг/
- Орхон аймаг дахь УБХ урсгал засварын зардлаас бэлтгэсэн 2.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд НБББББ-т заасны дагуу тусгаагүй байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс 887.9 сая төгрөг болж, өмнөх оноос 780.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,954.1	-	(1,954.1)
Байгууллагад төлөх өглөг	5,626.0	1,698.7	(3,927.4)
Хувь хүмүүст төлөх өглөг	2,424.8	-	(2,424.8)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	10,830.1	51,270.8	40,440.7
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	86,368.4	834,923.2	748,554.8
Дүн	107,203.4	887,892.7	780,689.3

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны 94.0 хувь буюу 834.9 сая төгрөгийг урьдчилж орсон орлого эзэлж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гэрээний үүргийн дагуу суутгасан барьцаа хөрөнгө байна.

Аудитын илрүүлэлт:

Сэлэнгэ аймаг дахь УБХ өмнөх онд үүссэн 3.9 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгэж тайлагнаагүй.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо данс 52,806.5 сая төгрөг болж, өмнөх оноос 18,917.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	12,211,503.2	12,211,503.2	-
Хуримтлагдсан үр дүн	21,167,084.8	40,084,186.0	18,917,101.2
Өмнөх үеийн үр дүн	7,301,309.1	21,252,077.2	13,950,768.1
Тайлант үеийн үр дүн	13,865,775.7	18,832,108.8	4,966,333.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	510,784.3	510,784.3	-
Дүн	33,889,372.4	52,806,473.5	18,917,101.2

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 18,917.1 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 8,993.2 сая төгрөгийн барилгыг хүлээн авсан, тайлант оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 10,391.3 сая төгрөгийн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн болон тайлант оны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 53,330.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт зарлагыг 11,273.7 сая төгрөгөөр бууруулж, нийт 42,056.8 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээнд зориулан 42,056.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 31,615.8 сая төгрөгийг урсгал зардалд, 10,441.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр 42,056.8 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 31,615.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 10,391.3 сая төгрөг, нийт 42,007.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, төлөвлөснөөс 49.8 сая төгрөг дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 41,954.9 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлыг 51.5 сая төгрөгөөр, санхүүжилт дутуу олгогдсоноос шалтгаалсан байна. Зарцуулаагүй үлдэгдэл 52.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт-10 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70406	Улсын бүртгэл, мэдээлэл	42,056,773.8	41,954,970.1	101,803.7	99.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	22,009,327.3	21,957,550.9	51,776.4	99.9
1.2	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	6,937.1	6,828.0	109.1	98.4
1.3	80220	Холбооны суваг ашигласны хөлс	415,286.1	415,285.7	0.4	100.0
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	750,723.3	750,285.7	643.2	99.9
1.5	81501	Ерөнхийлөгчийн сонгууль	2,900,000.0	2,900,000.0	-	100.0
1.6	81521	Иргэний үнэмлэх хэвлэх, тараах	5,533,500.0	5,533,301.9	198.1	100.0
1.7	80918	Бусад /хөрөнгийн зардал/	10,441,000.0	10,391,352.9	49,647.1	99.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Аймаг нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 632.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 80.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 2,229.8 сая төгрөг, нийт 2,942.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 2,913.5 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 15,848.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 13,242.4 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах 7 зорилтын хүрээнд 59 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 96.1 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд улсын бүртгэл мэдээллийн чиглэлээр 5 хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг баталсан байна.

Хүснэгт 11 Хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2021 оны зорилтот түвшин	2021 оны хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
21.3	Улсын бүртгэл мэдээлэл				
	21.12.1	Цахим үнэмлэх олголт /мянган хүнээр/	260.0	238.9	91.9
	21.12.2	Цахим хэлбэрт шилжүүлсэн архивын баримтын тоо /мянгаар/	4,800.0	5,951.4	124.0
	21.12.3	Бэлтгэсэн улсын бүртгэлийн маягт /мянгаар/	2,357.7	2,114.2	89.7
	21.12.4	Дүгнэлт гаргах хяналт шалгалтын тоо /мянгаар/	3.0	8.0	266.7
	21.12.5	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх /сая төгрөг/	17,000.0	16,069.0	94.5

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн гүйцэтгэл, зорилтот түвшнээс давсан үзүүлэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд Сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, дэд төлөвлөгөө гарган Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжоор улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны а/11 дүгээр тушаалаар байгуулж, Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө /6 бүлэг бүхий 94 арга хэмжээ бүхий/-г баталж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан болон тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн тайлбарыг тухай бүр мэдээлээгүй;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа байгууллагууд Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх 22 байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд нийт 3299 мэдээллийг байршуулснаас 138 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар илэрсэн нийт 148.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг өгсөн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт.11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	8	19,838.3	8	19,838.3	-	-	100.0
Албан шаардлага	17	560,083.9	17	560,083.9	-	-	100.0
Зөвлөмж	26	97,788.0	26	97,788.0	-	-	100.0
Нийт дүн	51	677,710.2	51	677,710.2	-	-	100.0

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 690.9 сая төгрөгийн 74 алдаа, зөрчил илрүүлснээс 240.7 сая төгрөгийн 29 алдааг аудитын явцад залруулж, 1.7 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 84.1 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 364.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 26 зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 301.6 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 1,089.8 сая төгрөгөөс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 21 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 21 дүгнэлт өглөө.

Түүврийн байгууллага

Улсын бүртгэлийн ерөнхий газар аж ахуй нэгжтэй байгуулсан 49.8 сая төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, акт үйлдээгүй, харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, акт үйлдэж байх, алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар нийт 428.7 сая төгрөгийн 62 алдаа, зөрчил илрүүлснээс 127.1 сая төгрөгийн 18 алдааг аудитын явцад залруулж, 1.8 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 84.2 сая төгрөгийн 13 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 215.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 24 зөвлөмжийг хүргүүллээ.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 690.9 сая төгрөгийн 73 алдаа, зөрчил илрүүлснээс 240.7 сая төгрөгийн 29 алдааг аудитын явцад залруулж, 1.7 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 84.1 сая төгрөгийн 13 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 364.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 26 зөвлөмжийг хүргүүлсэн нь дотоод аудитын ажил хангалтгүй, удирдлагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах, алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

д/ д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт			Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Түүвэрт хамруулсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагч																	
1	УБЕГ	АХГ-2022/17/НА-СТА-ТТЗ	1	1		1	-					1	-				
Дүн			1	1	-	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Төсвийн шууд захирагч																	
1	Архангай аймаг дахь УБГ	АРА-2022/34/НА-СТА-ТШЗ	1	1		2	-					1	-			1	-
2	Баян-Өлгий аймаг дахь УБГ	БӨА-2022/169/НА-СТА-ТШЗ	1	1		-	-										
3	Баянхонгор аймаг дахь УБГ	БНА-2022/105/НА-СТА-ТШЗ	1	1		3	4,741.2	1	3,108.9	1	293.9	1	1,338.4				
4	Булган аймаг дахь УБГ	БУА-2022/117/НА-СТА-ТШЗ	1	1		3	295.5					1	87.5			2	208.0
5	Говь-Алтай аймаг дахь УБГ	ГАА-2022/74/НА-СТА-ТШЗ	1	1		5	12,193.0	1	2,200.0	1	237.0	3	9,756.0				
6	Говьсүмбэр аймаг дахь УБГ	ГСА-2022/22/НА-СТА-ТШЗ	1	1		12	75,209.2	9	74,797.9	1	411.3					2	-
7	Дорноговь аймаг дахь УБГ	ДГА-2022/162/НА-СТА-ТШЗ	1		1	1	1,487.8									1	1,487.8
8	Дорнод аймаг дахь УБГ	ДОА-2022/158/НА-СТА-ТШЗ	1	1		2	48,900.0									2	48,900.0
9	Дундговь аймаг дахь УБГ	ДУА-2022/2/НА-СТА-ТШЗ	1	1		2	38,846.1	2	38,846.1								
10	Завхан аймаг дахь УБГ	ЗАА-2022/195/НА-СТА-ТШЗ	1	1		1	2,100.0									1	2,100.0
11	Өвөрхангай аймаг дахь УБГ	ӨВА-2022/120/НА-СТА-ТШЗ	1	1		2	1,332.1	1	532.1							1	800.0
12	Өмнөговь аймаг дахь УБГ	ӨМА-2022/112/НА-СТА-ТШЗ	1	1		1	51.5	1	51.5							1	-
13	Сүхбаатар аймаг дахь УБГ	СБА-2022/18/НА-СТА-ТШЗ	1	1		-	-										

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	Сэлэнгэ аймаг дахь УБГ	СЭА-2022/260/НА-СТА-ТШЗ	1	1		6	41,261.2			2	669.2	2	3,871.5			2	36,720.5
15	Төв аймаг дахь УБГ	ТӨА-2022/04/НА-СТА-ТШЗ	1	1		7	39,763.9	3	31,224.0	1	183.0	2	5,106.8			1	3,250.1
16	Увс аймаг дахь УБГ	УВА-2022/53/НА-СТА-ТШЗ	1	1		-	-										
17	Ховд аймаг дахь УБГ	ХОА-2022/17/НА-СТА-ТШЗ	1	1		2	37,500.0									2	37,500.0
18	Хөвсгөл аймаг дахь УБГ	ХӨА-2022/246/НА-СТА-ТШЗ	1	1		2	100,200.0	1	4,200.0							1	96,000.0
19	Хэнтий аймаг дахь УБГ	ХЭА-2022/10/НА-СТА-ТШЗ	1	1		1	1,200.0					1	1,200.0				
20	Дархан-Уул аймаг дахь УБГ	ДАА-2022/132/НА-СТА-ТШЗ	1	1		2	59,662.5	1	1,536.0							1	58,126.5
21	Орхон аймаг дахь УБГ	ОРА-2022/23/НА-СТА-ТШЗ	1	1		4	18,959.1					1	12,971.5			3	5,987.6
22	Нийслэлийн УБГ	ХАК-2022/783/НА-СА-ТШЗ	1	1		14	157,478.4	9	84,266.6							5	73,211.8
23	УБЕГ-аппарат	АХГ-2022/329/НА-СТА-ТШЗ	1		1	1	49,817.5					1	49,817.5				
Дүн			23	21	2	73	690,999.0	29	240,763.1	6	1,794.4	13	84,149.2	-	-	26	364,292.3
НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН			24	22	2	74	690,999.0	29	240,763.1	6	1,794.4	14	84,149.2	-	-	26	364,292.3

5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн шилэн дансны алдаа зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагч														
1	УБЕГ	АХГ-2022/17/НА-СТА-ТТЗ	1	-					1	-				
Дүн			1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Төсвийн шууд захирагч														
1	Булган аймаг дахь УБГ	БУА-2022/117/НА-СТА-ТШЗ	1	-									1	-
2	Өмнөговь аймаг дахь УБГ	ӨМА-2022/112/НА-СТА-ТШЗ	1	-									1	-
3	Ховд аймаг дахь УБГ	ХОА-2022/17/НА-СТА-ТШЗ	1	-	1	-								
4	Хөвсгөл аймаг дахь УБГ	ХӨА-2022/246/НА-СТА-ТШЗ	1	96,000.0									1	96,000.0
5	Дархан-Уул аймаг дахь УБГ	ДАА-2022/132/НА-СТА-ТШЗ	1	52,680.6									1	52,680.6
Дүн			5	148,680.6	1	-	-	-	-	-	-	-	4	148,680.6
НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН			6	148,680.6	1	-	-	-	1	-	-	-	4	148,680.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 693/A0160062

Улаанбаатар хот

АХТ - 2022/17/НА-СТА-ТЛЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу гүйцэтгэсэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 400,418,419.00 төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,794,433.00 төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 34,331,700.00 төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 12 албан шаардлага, 364,292,286.00 төгрөгийн 28 зөвлөмж хүргүүлсэн нь дотоод аудитын ажил хангалтгүй, удирдлагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Ахлах нягтлан бодогч Ч.Баасансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ

Б ЭНХЖИН

Э БҮГҮНҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-347.Docx
90061099
9019120396

0001081751



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 694/А0160062

Улаанбаатар хот

АХТ-2022/17/НА-СТА-JTS

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу гүйцэтгэсэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан болон тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн тайлбарыг тухай бүр мэдээлээгүй;
2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх 22 байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд нийт 3299 мэдээллийг байршуулснаас 138 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Ахлах нягтлан бодогч Ч.Баасансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.ЭНХЖИН

Э.БҮГҮНҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Nchig_Khere\Alban_Shaardlaga\2022\0325_Audit_2_Баян-3\4.Docs

4006109
9019120396

0001081749



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 695/АД/60062

Улаанбаатар хот

АХТ-2022/17/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу гүйцэтгэсэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж ахуй нэгжтэй байгуулсан 49,815,700.00 төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, акт үйлдээгүй, харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, акт үйлдэж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Ахлах нягтлан бодогч Ч.Баасансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Б.ЭНХЖИН

Э.БҮГҮНҮТЭЙ

[illegible]

[illegible]